“КИБЕР ХАЛДЛАГА, ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ НИЙТИЙН ТӨВ” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Зорилт.1 Захиргаа удирдлагаар хангаж, хүний нөөцийг хөгжүүлэх зорилтын хүрээнд							**98.75%**
1.1	Монгол Улсын Засгийн газрын 12 дугаар сарын 16-ны өдрийн 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах” журмын 2.3-т заасны дагуу стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	Дотоод нөөц	Баталгаажуулсан баримт бичгийн тоо	-	1	“Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” УТҮГ-ын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө”-ний төслийг боловсруулан 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд цахимаар хүргүүлсэн.	90%
1.2	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах” журмын 2.1-д заасны дагуу Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг журмын дагуу удирдах дээд байгууллагад хүргүүлэх	Дотоод нөөц	Баталгаажуулсан баримт бичгийн тоо	-	4	Захиргаа удирдлагын газар, Мэдээлэл дүн шинжилгээний газар, Кибер халдлагаас урьдчилан сэргийлэх газар, Кибер халдлагад хариу үзүүлэх газруудын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр тус тус баталсан. “Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв” УТҮГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЦХХХ-ы Сайд Н.Учрал 2024 оны 02 дугаар сарын 09-ны өдөр баталсан.	100%
Зорилт 2. Нийтийн төвийн гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх үйл ажиллагааны ил тод байдлыг хангах							**100%**
2.1	Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх арга хэмжээ авах	Дотоод нөөц	Монгол Улсын болон гадаад орны ижил төстэй байгууллагатай	-	2	1.Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE)-н (Cyber/ICT security CBMs)-ний	100%

			эрх хэмжээний хүрээнд хамтран ажилласан байна.			хүрээнд ашиглаж буй харилцаа холбооны сүлжээнд нэгдсэн. 2.Дэлхийн Кибер халдлагад хариу үзүүлэх төвүүдийн холбоо (FIRST)-д 2024 оны 06 дугаар сарын 14-ны өдөр албан ёсоор элссэн.	
			Олон улсад зохион байгуулагдах салбарын арга хэмжээнд оролцсон байх.	-	2	1.Мета ногоон суваг өргөжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор тус компанийн Сингапур Улс дахь салбарын холбогдох ажилтнуудтай уулзалт, хэлэлцээрийг зохион байгуулах багт ажилласан. 2.АНЭУ-ын Кибер аюулгүй байдлын зөвлөлөөс зохион байгуулсан бага хуралд оролцсон. 3.Тайвань улсад APCERT болон FIRST хамтран зохион байгуулсан бүс нутгийн кибер аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн мэдлэг туршлага, мэдээлэл солилцох хуралд оролцсон.	100%
2.2	Олон улсын байгууллагатай байгуулах гэрээ, хэлэлцээрийн төслийг орчуулах, батлагдсан гэрээ хэлэлцээрийг бүртгүүлнэ	Дотоод нөөц	Баталгаажуулсан баримт бичгийн тоо	0	2	1.Япон улсын JPCERT байгууллагатай харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. 2.“OffSec” олон улсын сургалтын байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, Government partner болон хамтран ажиллаж байна.	100%
Зорилт 3. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дотоод сургалтын төлөвлөгөөг батлуулах, сургалтыг тухай бүр зохион байгуулахад нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.							**100%**
3.1	Сургалтын төлөвлөлөө боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангах	Улсын төсвийн санхүүжилт	Баталгаажуулсан баримт бичгийн тоо	0	1	Сургалтын төлөвлөгөөний дагуу мэргэжилтнүүдийг нарийн мэргэшүүлэн чадавхжуулах зорилгоор улсын төсөв болон олон улсын байгууллагын санхүүжилтээр холбогдох сургалтуудад тогтмол хамруулж байна.	100%

3.2	Албан хаагчдын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшнийг үнэлэх ажлыг зохион байгуулах	Дотоод нөөц	Зохион байгуулсан тоо	0	1	Олон улсын IT аюулгүй байдлын үндсэн мэдлэгийн түвшинг үнэлэх шалгалтын агуулгын хүрээнд мэргэжилтнүүдэд үнэлгээ хийж гүйцэтгэсэн.	100%
Зорилт 4. Мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр хийлгэх хуулийн хэрэгжилтийг хангуулах							**100%**
4.1	Мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тайланг хүлээн авч, зөвлөмж, шаардлага хүргүүлэх	Дотоод нөөц	Хувийн хэвшлийн ОЧМДББ-ын 10-аас доошгүй хувь нь хамрагдсан байна.	-	10 хувь	ОЧМДББ болон хувийн хэвшлийн байгууллагуудад шаардлага, зөвлөмж хүргүүлж, нийт 8 (10.52%) байгууллагаас Мэдээллийн аюулгүй байдлын аудитын тайланг хүлээн авсан.	100%
4.2	Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй хувийн хэвшлийн байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар мэдээлэл өгөх	Улсын төсвийн санхүүжилт	10 удаа уулзалт зохион байгуулсан байна.	1	10	1. Финтекийн зээлийн үйлчилгээ үзүүлэгч хувийн хэвшлийн компаниудыг оролцуулан FINSEC форум зохион байгуулсан. 2. **47** хувийн хэвшлийн эмнэлгийн байгууллагуудын дунд уулзалт зохион байгуулж, кибер аюул заналаас урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдээлэл хүргүүлсэн. 3. "Кибер тусгаар тогтнол II" форумыг Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албатай хамтран зохион байгуулсан. Форум нь төр, иргэн, хувийн хэвшил хооронд харилцан мэдээлэл солилцож, аюулгүй байдлын хэм хэмжээ, стандарт тогтоон мөрдөх, кибер гэмт хэргээс сэргийлэхэд хамтран ажиллаж, мэдээллийн нууцлалтай, бүрэн бүтэн, хүртээмжтэй байдлыг хангах арга замуудаа тодорхойлоход чухал үр дүнг үзүүллээ. 4. Голомт банк, Худалдаа хөгжлийн банк, Интермед, Юнител, E-Clinic, Playmaker	100%

						зэрэг 6 байгууллагуудын дарк веб дээрх мэдээллийг хайж, уулзалт зохион байгуулсан. 5. Хас банк болон “Бүрэн скор ЗМС” ХХК-иудад хяналт шалгалт хийж, мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч ажилласан.	
Зорилт 5. Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалт зохион байгуулах							**100%**
5.1	Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр мэргэшүүлэх сургалт зохион байгуулах мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагыг сонгон шалгаруулж бүртгэх, үйл ажиллагааг эхлүүлэх	Дотоод нөөц	Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр мэргэшүүлэх сургалт зохион байгуулах мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагыг сонгон шалгаруулах, бүртгэх журам боловсруулсан байна.	0	1	Сургалтын үйл ажиллагаа эрхлэх хууль эрх зүйн орчин хараахан бүрдээгүй байгаа тул ШУТИС-ийн Мэдээлэл Холбооны Технологийн Сургуультай хамтран Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж байна.	100%
			Сургалтын хөтөлбөр боловсруулсан байна.	0	1	1.Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн төслийг ШУТИС-ийн Мэдээлэл Холбооны Технологийн Сургуультай хамтран сургалтын хөтөлбөр батлуулсан. 2.“Цахимд зөв байя” аяны хүрээнд Захиалгат мэдээллийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр боловсруулсан.	100%
			Сургалт хийх байгууллагыг бүртгэж, үйл ажиллагааг эхлүүлсэн байна.	0	3	1.Удирдлагын академи, ШУТИС-ийн Мэдээлэл Холбооны Технологийн Сургуультай хамтран “Цахим засаглалын төлөв, цаашдын чиг хандлага” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтад төрийн дээд байгууллагууд болон	100%

						яамдын Кибер аюулгүй байдал хариуцсан **35** албан хаагч хамрагдсан. 2.Удирдлагын академи, ШУТИС-ийн Мэдээлэл Холбооны Технологийн Сургууль, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Кибер халдлага зөрчилтэй тэмцэх үндэсний төвтэй хамтран “Цахим засаглалын төлөв, цаашдын чиг хандлага (кибер аюулгүй байдал)” сургалтыг зохион байгуулсан бөгөөд сургалтад Засгийн газрын агентлагуудын **36** албан хаагч хамрагдсан. 3.Удирдлагын академи, ШУТИС-ийн Мэдээлэл Холбооны Технологийн Сургуультай хамтран МАБ-ын чиглэлээр мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулсан бөгөөд сургалтад ГЕГ, ЗТХЯ, МЭЕГ, УА, ШУТИС МХТС, Төрийн банкны нийт **9** албан хаагч хамрагдсан. 4.Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтарсан “Цахимд зөв байя” аяны хүрээнд Сэлэнгэ, Булган, Орхон, Өмнөговь болон Дундговь аймгуудад сургалтыг амжилттай зохион байгуулсан.	
Зорилт 6. Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх							**100%**
6.1	Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Улсын төсвийн санхүүжилт	Иргэд, олон нийтэд кибер аюулгүй байдлыг хангах талаар мэдээлэл, сурталчилгааг тогтмол түгээсэн байна.	0	80	Нийт **117** видео болон постер бэлтгэж олон нийтэд түгээсэн. *(Постер - 57, Видео - 50)*	100%

			Кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх аян зохион байгуулсан байна.	0	1	“Цахимд зөв байя” аяны хүрээнд 21 аймаг болон нийслэлийн 9 дүүрэгт зохион байгуулсан сургалтад нийт **25000** орчим хүн хамрагдсан.	100%
Зорилт 7. Кибер халдлага, зөрчлийн талаар судалгаа, дүн шинжилгээ хийх							**73.3%**
7.1	Цахим орчинд ажиглалт, туршилтын аргаар судалгаа хийх	Улсын төсвийн санхүүжилт	Фейсбүүк платформ хэрэглэгчдийн эмзэг байдлын судалгааг хийсэн байна.	0	3	Судалгаа хийх 3 программыг хөгжүүлэн судалгааны ажлыг эхлүүлэхэд бэлэн болсон. Фейсбүүк платформ дээр “хүлээгдэж байгаа” төлөвтэй байгаа тул судалгааг явуулах боломжгүй байна. Тус төлөв хэвийн горимд шилжмэгц уг ажлыг эхлүүлэхээр шийдвэрлэсэн.	50%
7.2	Кибер аюулгүй байдалд тулгамдаж буй асуудлын талаар хувийн хэвшлийнхнээс судалгаа авах	Улсын төсвийн санхүүжилт	Судалгааг хийсэн байна.	0	1	Кибер аюулгүй байдалд тулгамдаж буй асуудлын хүрээнд анкетын асуулга бэлтгэсэн. Судалгааны цар хүрээнээс хамааран 2025 оны I улиралд 2 үе шаттайгаар судалгааг эхлүүлэхээр шийдвэрлэсэн.	70%
7.3	Төрийн байгууллагуудаас интерактив аргаар эмзэг байдлын судалгаа хийх	Улсын төсвийн санхүүжилт	Судалгааг хийсэн байна.	0	1	“Цахимд зөв байя” аяны хүрээнд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран Нийслэлийн 2 дүүрэг болон Сэлэнгэ, Булган, Орхон, Өмнөговь, Дундговь,Төв аймгуудад фишинг халдлагын туршилтыг хийж судалгаа авсан ба кибер аюулгүй байдлын чиглэлээр сургалт зохион байгуулсан.	100%
Зорилт 8. Кибер халдлагад хариу үзүүлэх							**100%**
8.1	Монгол улсын интернэт сүлжээний орчин дахь кибер аюул занал, нөхцөл байдлын талаар 7 хоног тутамд тандалт хийх	Улсын төсвийн санхүүжилт	Тайлангийн тоо	5	52	Монгол улсын IP хаягт хамаарал бүхий сэжигтэй үйлдэл, халдлагын мэдээллийг Abuse.ch, DataPlane.org, SANS ISC, ShadowServer, Spamhaus	100%

						Private, Team Cymru, Telia ZONE-H гэх мэт индикатор эх сурвалжаас авч 7 хоног тутамд кибер аюул заналын нөхцөл байдлын талаар тандалт, дүн шинжилгээ хийж тайланг тогтмол хүргүүлэн ажилласан.	
8.2	Сар бүр Монгол улс болон бүс нутаг руу чиглэсэн хортой кодын статик, динамик шинжилгээг хийх, зөрчлийг бууруулах, арилгах зөвлөмж боловсруулах	Улсын төсвийн санхүүжилт	Тайлангийн тоо	1	12	Монгол улсад хамгийн их илэрч байгаа хортой кодоос сар бүр сонгон авч статик, динамик шинжилгээг тогтмол хийж хортой кодод хариу үзүүлэх зөвлөмжийг боловсруулан ажилласан. Нийт **14** зөвлөмж боловсруулж хүргүүлсэн.	100%
8.3	Кибер халдлага, зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах сувгуудыг бүрэн ажиллагаанд оруулах	Улсын төсвийн санхүүжилт	Мэдээлэл авах сувгийн тоогоор	0	3	Иргэн, хуулийн этгээдээс дуудлага, мэдээлэл хүлээн авах 113 тусгай дугаар, 113.mn, цахим сувгуудаар кибер халдлага зөрчлийн мэдээг тогтмол хүлээн авч ажиллаж байна.	100%
8.4	Кибер халдлага, зөрчил хүлээн авах сувгуудаар иргэд, хуулийн этгээд, хувийн өмчит онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудаас хүлээн авсан мэдээлэлд тулгуурлан кибер халдлага, зөрчилд шинжилгээ хийж хариу үзүүлэх	Улсын төсвийн санхүүжилт	Хэрэгжилтээр	0	-	Хуулиар хүлээсэн чиг үүрэгт хамааралтай нийт **9** халдлага зөрчлийн мэдээлэл бүртгэгдсэн. Мөн Монгол Улсын харьяалал бүхий **178** IP хаягийн хэрэглэгчийн мэдээллийн систем хортой кодын халдлагад өртсөнийг илрүүлж, холбогдох эзэмшигчийг интернэт үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хамтран тогтоож, хортой кодын халдлагыг таслан зогсоох, нөхөн сэргээх зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.	100%

-----o0o-----